



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2012 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 11008

Булган

Гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган сумын Сансар цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг “Эй энд Жи Монолит” ХХК-тай 34 000 000 /гучин дөрвөн сая/ төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Булган сумын Хот тохижуулах ангийн дарга /Н.Баасанжаргал/-д олгосугай.

2. “Эй энд Жи Монолит” ХХК-тай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, ажиллахыг Булган сумын Хот тохижуулах ангийн дарга /Н.Баасанжаргал/-д үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эй энд Жи Монолит” ХХК /М.Энхсайхан/-д даалгасугай.

4. Гэрээнд заасан ажлын санхүүжилтийг аймгийн төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ